



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/22 ДУА-2018/25/СТА-ТӨС

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-г заасан бүрэн эрхийн хүрээ, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9 дэх заалт, аймгийн Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад нийт 1,068,357.44 төгрөгийн зөрчил илэрлээ.

Үүнд:

1. Батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй нийт 886,874.44 /найман зуун жаран зургаан мянга найман зуун далан дөрвөн өдчин дөрвөн мөнгө/ төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол Улсын ЗГ-ын 2006 оны 05 сарын 10-ны өдрийн 103 тоот тогтоолоор “Дотоодын болон ерөнхий зориулалтын цэргийн албан хаагчдын хүнсний хангамжийн хоногийн хоолны хэм хэмжээ”-г зөрчсөн байна.

2. Цалингийн зардлаас Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 201,483.00 /хоёр зуун нэг мянга дөрвөн зуун наян гурав/ -н төгрөгийг шилжүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-г /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-г /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм,

журмын шаардлага нөхцөлийг хангаагүй / 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Нормативт зардлыг хяналтгүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Онцгой байдлын газрын дарга Я.Алтанхундага, нягтлан бодогч Б.Сайнзаяа нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АХЛАХ АУДИТОР Т.БАТСАЙХАН



ЗӨВШӨӨРСӨН:

ТШЗ Я.АЛТАНХУНДАГА  
НЯГТЛАН БОДОГЧ Б.САЙНЗАЯА



<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэнэ/